

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-18

1.Хаврын тариалалтын явцын байдлын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох	3-18
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 03 дугаар сарын
19-ний өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 28 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Н.Наранбаатар;

Чөлөөтэй: Ц.Анандбазар, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Д.Өнөрболор;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Саранчимэг.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ц.Идэрбат, Ц.Туваан, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Нэг.Хаврын тариалалтын явцын байдлын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн дарга Н.Оюунсүвд, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Отгонбаатар нар байлцав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун Хаврын тариалалтын явцын байдлын талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Т.Энхтүвшин, Г.Ганболд нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Байнгын хорооны дарга Ж.Батжаргал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хаврын тариалалтын явцын байдлын талаар мэдээлэл сонсов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 00 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 18 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим,
17 цаг 28 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ ӨЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Батжаргал: Байнгын хорооныхоо эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байгаль орчин, хүнс, хөдөө өж ахуйн байнгын хорооны 2024 оны 03 дугаар сарын 19-ний хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс одоогийн байдлаар 11 гишүүн хүрэлцэн ирж, ирц 57,9 хувьтай байна. Тийм учраас хуралдаан эхлэх бололцоотой ирц бүрдсэн байх тул өнөөдрийн хуралдааныг эхлүүлж байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх 1 асуудал байна.

Хаврын тариалалтын бэлтгэл ажлын явцын мэдээлэл сонсох асуудал байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай, асуулттай гишүүн байна уу? Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Гишүүдэд оройн мэнд хүргэе. Тэгээд яах вэ, би энэ манай Байгаль орчин, хүнс, хөдөө өж ахуйн байнгын хорооны энэ чуулган нээгдсэнээс хойш анхны хурал болж байна. Энэ хурлаар би уг нь хамгийн түрүүнд энэ зудын байдлыг бид нар ярих ёстой. Тэгээд энэ салбарын хамгийн том бодлогыг барьж байгаа төрийн хамгийн том бүтцийн байгууллага энд явж байгаа учраас бид нар ярих ёстой л гэсэн ийм бодолтой байгаад байгаа юм. Байгаль, цаг уурын нөхцөл байдал өөрчлөгдөж байгааг хүн болгон ярьж

байгаа. Сүүлийн 60 жилийн судалгаагаар аваад үзэхэд ус бороо, цас бол угаасаа жилийн жилд нэмэгдэх юм байна лээ. Зудтай холбоотой асуудлаар бүгдээрээ л энэ чуулган завсарласан үеэр явцгаалаа. Бид нарыг сонгоод, дэмжээд энэ Их Хуралд төлөөлөл болгоод явуулсан хүмүүс маань биднийг шуудай гурил, хивээг үүрээд 5, 10 кг будаа, гурил тараагаад яв гэж сонгоогүй. Би ч юм уу, хэн ч юм ийм хүмүүсийг. Биднийг, бидний малын махыг үнэтэй болгоод өгөөч ээ, малын дайвар бүтээгдэхүүнүүдийг боловсруулдаг үйлдвэрүүдтэй болгоод өгөөч ээ, Монгол малыг эрүүлээр экспортолдог болгоод өгөөч ээ гэдэг энэ эрх зүйн орчныг бүрдүүлж өгөөч ээ л гэж сонгож явуулсан гэж би бол ойлгоод байгаа юм.

Сая бид нар баахан тариалангийн асуудал ярилаа. Монголын тариаланг өөд нь татах юм нь бол энэ мал аж ахуйгаа өөд нь татах л юм байна лээ шүү дээ. Ногоон тэжээл, буурцагт ургамлууд гээд шинэ төрлийн энэ ургамлуудыг тарьж энэ малын тэжээлийн салбарыг өөд нь татаж байж бид нар энэ тариаланчдынхаа ашиг орлогыг ч нэмэх юм байна лээ, мал аж ахуйн салбараа ч өөд нь татах юм байна лээ шүү дээ. Малын идэж байгаа өвс тэжээл, ургамал эрүүл гэдгийг баталдаг хууль, эрх зүйн орчноо сайжруулах ёстой юм байна. Дэлхийн ургамлын аюулгүй байдлыг хамгаалах байгууллагад нэгдэж орсон юм бол бид нар энэ хуулиа сайжруулаад, агентлагийг нь байгуулах ёстой юм байна. Энэ агентлаг нь Монгол орны тодорхой бүс нутгийн өвс ургамал эрүүл юм, саруул юм гэдгийг баталж олон улсад хүлээн зөвшөөрүүлэх ажлыг хийх хэрэгтэй байна. Бодлогын түвшинд. Энэ эрх зүйн орчныг ярьа.

2 дугаарт, энэ малын хариулж байгаа адгуулж байгаа өсгөж байгаа газар нь эрүүл юм гэдгийг бас бид нар бий болгох ёстой болчихоод байна. Улсаараа бид нар өвчингүй малын өвчингүй болох гэж үзээд барсангүй,

бүсээрээ болох гээд барсангүй. Одоо ашгүй нэг юм саяхан өнгөрсөн хаврын чуулганаар бид нар ярьж байгаад энэ хамгаалалттай аж ахуйн нэгжүүдийн асуудлыг оруулж ирсэн. Хөдөө аж ахуйн яам дээр журам нь явж байгаа юм байна лээ. Харамсалтай нь манай улсын энэ мал эмнэлгийн том агентлаг нь өөрөө олон улсад хүлээн зөвшөөрөгдөөгүй энэ лабораториос гарч байгаа үнэлгээ, дүгнэлтийг дэлхий хүлээн зөвшөөрдөггүй. Ийм учраас бид нар мал махаа гадаадад экспортлож чаддаггүй. Дулааны аргаар буюу чанаж байгаад гаргачихсан энэ мах нь л өөрөөр хэлбэл хамгийн хямд үнэтэйгээр л гарч байгаа мах байхгүй юу. 1кг нь нэг 2 доллар л хурч байгаа байх. Ийм асуудлуудыг бид нар яримаар байна.

3 дугаарт, энэ төхөөрч байгаа газрууд нь мах комбинатууд нь бас эрүүл ахуйн шаардлага хангасан гэдгийг бий болгодог энэ стандарт, ном журмынх нь хууль дүрмээ бид нар сайжруулмаар байна. Энэ асуудлуудыг ярьж байж бид нар энэ зудтай тэмцэнэ. Малчин хүнийг өнөөдөр бид нар малаа эрчимжүүл, малаа цөөрүүл, нөхөрлөл байгуул гэж шахаад ямар ч нэмэргүй шүү дээ. Маллаж байгаа малыг нь цөөлөөд, ашиг шимийг нь нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалт хэрэгтэй, шинжлэх ухаан хэрэгтэй. Үүнийг хэн хийх юм. Төр хийж чадахгүй. Үүнийг зөвхөн аж ахуйн нэгжүүдийг энэ салбарт орж ажиллаж болдог энэ орчныг нь бүрдүүлж байж л бид нар хийлгэнэ. Малчин хүн малаа Мах комбинатад аваачиж өгөх нь өөрт нь ашигтай байдаг. Үнэ нь өндөр байдаг. Тэр Мах комбинат нь өөрөө малын энэ өвчнөөсөө сэргийлэх мал эмнэлгийн үйлчилгээгээ давхар үзүүлээд явчихдаг, малынх нь үржил шимийг сайжруулахад тусалчихдаг, ногоон тэжээлээ тарихад нь тусалдаг, инновац нэвтрүүлэхэд нь тусалдаг ажлуудыг хийж байж, энэ салбар өөдөө гардаг юм байна лээ. Үүнийгээ дагаад газар тариалангийн салбар бас өөдөө гарах юм байна лээ. Канад ч тэр, Австрали ч тэр бүгд л

ингэж мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбараа өөд нь татсан байна.

Би энэ салбарын хүн биш. Гэхдээ энэ зуд турхны байдал хүнд байгаа учраас судлахаас өөр аргагүй байдалд орлоо. Тэгэхээр бид нар энэ хууль, эрх зүйн орчноо Байнгын хороогоороо хамгийн түрүүнд ярья. Хаврын тариалалтаа ярилгүй л яах вэ. Тэгэхдээ бас давхар энэ асуудлуудыг ойрын үед Байнгын хорооны дарга хэдүүлээ Байнгын хороогоороо ярьж байгаад энэ зудтай холбоотой цаашид авах энэ бодлогын арга хэмжээгээ Их Хурлын гишүүд шиг нэг Их Хурлын түвшинд шиг нэг Их Хурлын түвшинд ярьцаая. Хэдүүлээ тэгэх үү. Тэгэхгүй алийн болгон тусламж яваад л, тэгээд л нэг хэдэн машин яваад л, хэдэн дарга нар яваад л, ямар ч үр дүн байхгүй шүү дээ, тэнд. Одоо энэ аргаасаа больцгооё.

Ж.Батжаргал: Хэлэлцэх асуудлын тухай ярьж байна. Дамдинням гишүүний ярьж байгаа асуудлуудыг ойлгож байгаа. Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын байдал дээр Улсын Их Хурал, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо бүх мэдээллүүдээ сонсоод, шийдвэрээ гаргачихсан. 16, 7 заалт дээр тогтоол гаргаад өгчихсөн. Тэр өнөөдөр яг үндсэндээ Монгол Улсын Засгийн газар, УОК шийдлүүдийг нь авч хэрэгжүүлээд ажиллаж яваа гэдгийг зориуд хэлмээр байна. Мал аж ахуйн салбараа өөрийг нь эрүүлжүүлэх, бүтээгдэхүүнийхээ өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх хүрээнд бид нар тодорхой хуулиуддаа өөрчлөлт өнгөрсөн чуулганаар хийсэн. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульдаа өөрчлөлт оруулаад, тайван бүс, хамгаалагдсан аж ахуйн тухай асуудлаа тусгаад оруулсан.

Одоо Хөдөө аж ахуйн тухай хууль өргөн баригдаад орж ирэх гэж байгаа. Үүгээр ер нь үндсэндээ энэ мал аж ахуйн салбарын өөрийнх нь тогтолцооны асуудал нэлээн тодорхой яригдаж, энэ цаг үеийнхээ нөхцөл байдалтай зохицож

хөгжих тухай асуудал нь яригдах ёстой,
1.

2 дугаарт, Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль гэж хуулийг орон нутгаас сонгогдсон 50 гаруй гишүүд үндсэндээ санал 1-тэй боловсруулаад, Засгийн газраас саналаа аваад одоо Засгийн газрын ирсэн санал дээр хуулийн төсөл дээрээ жоохон тодотгол юмнуудаа хийж байна. Энэ 5 дахь өдөр гэхэд Улсын Их Хуралд өргөн барина. Ингээд үүгээр бол энэ уламжлалт мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангах асуудлууд шийдэгдэнэ гэж л ингэж л хуулийнхаа үзэл баримтлал, боловсруулалтад гол анхаарлаа хандуулж хийсэн л гэж ингэж л хэлмээр байна.

Идэрбат гишүүн. Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Хэлэлцэх асуудалтай холбогдоод энэ цаг үеийн асуудал ярьж байгааг бол дэмжиж байна. Тэгэхдээ манай Байнгын хорооны хувьд энэ Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа хэд байгаа билээ. Хугацаа хэдий хэмжээний хугацаа үлдээд байгаа билээ. Тэгээд энэтэй холбогдуулаад энэ хаврын тариалалт ярьж байгаатай адилхан энэ хөдөө аж ахуйн салбар дээр үүсээд байгаа энэ зудын хохирлыг давж гарах тал дээр манай Байнгын хороо бас хэдүүлээ санаачилгатай ажиллая гэж би ингэж хэлэх гэж байгаа юм.

Малчдын хүсээд байгаа зүйл ер нь үндсэндээ нэг 4 зүйл л байгаа шүү дээ.

1 дүгээрт, зээл, зээлийн хүүгийн асуудлууд байгаа. Энэ дээр зохицуулалтууд явж байгаа. Харин энэ дээр манай Байнгын хороо ямархуу рольтой оролцох вэ гэхээр энэ арилжааны банк болон малын индексжүүлсэн даатгалын асуудлуудыг бид яах ёстой вэ. Энэ чинь бол тэгээд л хойшлуулсаар байгаад л бараг л нэг оны өмнө мөнгийг нь олгох гээд байдаг нэг

ийм юм яваад байдаг. Тэгээд бол малчид бол маш их харж байгаа. Өнгөрсөн 6 сард би энэ асуудлаар ажлын хэсэг гаргуулсан. Харамсалтай нь ажил нь яваагүй. Яг бахь байдгаараа байж байгаа юм.

2 дугаарт, сэг зэм сая Болорчулуун сайд ярилаа. Маргааш Засгийн газрын хуралдаанаар орох юм байна. Энэ бол нөгөө малын өвчин хуучтай холбоотой нэлээн бас урьдчилан сэргийлэх арга хэмжээ болох байх.

3 дугаарт, энэ малжуулах асуудал. Би өнөөдөр Нийгмийн бодлогын байнгын хороон дээр яг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам дээр ямархуу төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа юм бэ гэдэг дээр ирэх 7 хоногт тодруулга авъя гээд ингээд шийдчихсэн байгаа.

Манай Байнгын хорооны бас нэн тэргүүний хийх ажил бол 3 дугаарт, малчид энэ дараа дараагийн зудаас энэ малчин хүн хохирол багатай даван туулах тал дээр бид хууль, эрх зүйн энэ нэг баахан хаалттай юмнуудыг нь нээж өгөхгүй бол болохгүй юм байна лээ шүү дээ. Малчин хүн алга дарам газар ногоон тэжээл тарих эрх байхгүй. Байгалийн хадлан байхгүй. Боодол өвс худалдаад авъя. Мал нь үнэд хүрэхгүй. Намар юу, одоо тэрийг ярьдаг хүүхдийн сургалтын төлбөр энэ тэрээ гэж байгаад л өнгөрч байгаа шүү дээ. Тэгээд л цастай золгочхож байгаа юм.

Тийм учраас бид энэ Газрын хууль дээр ч тэр, энэ яригдаад байгаа асуудлуудаа бас нэг нээх тал дээр, нээж өгөх тал дээр бас нэг энэ Байнгын хороо бас нэг ажиллаасай гэж ингэж бас хүсээд байгаа юм. Тэгэхээр ер нь дараа дараагийн Байнгын хорооны хурлууд дээр бид яг энэ асуудлуудаар хуулийн төсөл юмнуудаа ч ярилцдаг. Энэ цаг үеийн нөхцөл байдлын сонсгол юмнуудаа ч бас холбогдох төрийн байгууллагуудаас нь сонсдог, чиглэл юмнуудаа өгдөг ийм юм

руугаа би бол бас жоохон энэ Байнгын хороо энэ үлдээж байгаа нэг 2, гуравхан сарын хугацаанд бас ажиллаасай л гэж ингээж хэлж байгаа юм.

Өнөөдрийн энэ хаврын тариалалттай холбоотой асуудлыг бол мэдээж дэмжиж байна. Дараа нь бас яах вэ, энэ Байнгын хороонд харьяалагдаж ажилласан гишүүний хувьд бид ард иргэдээс нэг баахан саналууд очоод л аваад л, газар дээр нь танилцаад л. Үгүй ээ, тэгээд эндээс ямар үр дүн гаргах гээд байгаа юм. Одоо би отрын бүс нутгийн асуудлаар энэ чинь Мөнхцэцэг гишүүн бид 2 Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан энэ Малхын тал гээд л баахан явсан, баахан ард иргэдийг цуглуулж байгаад саналыг нь авсан. Үгүй ээ, түүн дээр энэ отрын бүс нутгийг ингээд нэг энэ чигээр нь байлгаад өгөөч ээ гэж байгаа 1 ч хүн байхгүй байгаа шүү дээ. Тэгээд энэ асуудлаар би энэ Хөдөө аж ахуйн яам ямар саналтай байгаа юм бэ гээд нь асууя гэсэн. Бичгээр тодруулгыг нь авъя гэсэн. Тэр ирсэн бичгийг нь уншаад үзэхээр зүгээр нэг тийм бөөрөнхий л юм байгаа байхгүй юу. Би тэгж бөөрөнхий ажил хиймээргүй байна. Энэ орж ирэх асуудлуудаа үнэхээр энэ 9 отрын бүс нутгийн зарим нь бол хэвээрээ байя гэмээр баймаар байгаа юм. Зарим нь бол байхгүй болмоор байна гэж байгаа юм. Жишээ нь Малхын талын тэр отрын бүс нутгийг бараг хэдэн адуутай нөхдөд зориулаад гаргачихсан тийм л отрын бүс нутаг юм байна лээ шүү дээ. Малчдынх нь ярьж байгаа нь. Ямар ч өөрсдөөс нь тодруулга юмнууд аваагүй, тэнд хэн ордог вэ? Тэр олон малтай адуутай нөхөд л ордог юм байна лээ шүү дээ. Тэгээд тэнд байгаа нутгийн иргэд нь үйлээ үздэг л юм байна лээ шүү дээ. Тэгээд энэ мэтийг ингээд шийдье гээд ингээд үзэхээр ингээд Байнгын хороон дээрээс зүгээр бичгээр танилцуулга аваад Хөдөө аж ахуйн яамны танилцуулга нь тийм нэг бөөрөнхий юм ирсэн. Тэгээд би бол ард нь гараад мухарлачихмаар санагдаад байна. Тэгэхээр би Байнгын хороон дээр энэ отрын бүс нутгийн

асуудлыг эд нар бүр ингээд нэг нээлттэй яримаар байгаа юм.

Ж.Батжаргал: Идэрбат гишүүний саналууд дээр анхаармаар юмнууд байгаа байх. Тов тодорхой шаардлагатай асуудлууд байна гэвэл бүрэн эрхийнхээ хүрээнд асуудлаа санаачлаад оруулаад ирье, болно, ярилцъя. Тэр орж ирдэг ёс журмаар нь бүх юмнуудаа ярь.

Ер нь энэ Байнгын хороон дээр яригдаж хэлэгдсэн зүйлүүд тов тодорхой, бас ажил чиглэл болоод төрийн холбогдох байгууллагууд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээ авч ажиллаад яваад байгаа. Одоо таны ярьж байсан яриан дотроос тэр малын индексжүүлсэн даатгалын асуудал манай Байнгын хороон дээр ажлын хэсэг нь байж байгаа. Судалгаа тооцооллынх нь ажлууд одоо дуусаж байгаа юм гэнэ лээ. Өнгөрсөн жилийн зуд дээр тулгуурлаж энэ дээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх ёстой гэдэг байдлаар нь чиглэл юмнууд нь өгөгдсөн гэж би ингээж ойлгож байгаа шүү.

Туваан гишүүн.

Ц.Туваан: Отгон чуулганы манай салбарын Байнгын хорооны анхдугаар хуралдаан учраас бас хэлэлцэх асуудал дээр саналаа хэлье. Энэ сая үүний өмнө энэ Засгийн газраас нэн яаралтай горимоор энэ тэжээл, гурилын үнэтэй холбоотой шийдвэрүүд оруулж ирээд ингээд сая дэмжигдээд явлаа. Тэгэхээр бол энэ нэг тийм авцалдааны хувьд ч гэсэн миний хувьд бол яг 1 гараараа гурил үйлдвэрлэгч тэжээлийнхэн, дээрээс нь цаад талд нь байгаа тариаланчид дээр бол энэ сөрөг шийдвэр гарчихлаа. Тэгэхээр тэгээд залгуулаад бид нар хаврын тариалалтын бэлтгэл ажил гээд асуудал яригдаж байна. Тэгэхээр бол хойшлуулчихаж болохгүй юм уу гэсэн ийм саналыг хэлье.

Дээрээс нь гишүүд хэлж байна. Одоо бол яг нэн тэргүүний асуудал бол зудын асуудал байна. Тэгээд зудын асуудлыг ярьж байгаа учраас нуришаад яах вэ. Тэгэхдээ тодорхой шийдлүүдийг ярьж байгаа. Тэр нь 1 дүгээрт нь, малчны зээл тэглэх. Бүх зээл 1,3 их наяд. Энэ дотроос эрсдэлтэй, тодорхой хотоо харлуулаад, малаа 100 хувь алдчихсан хүмүүсийн асуудлыг ялгаад малыг нь энэ зудын дараа тоолоод, баримтжуулаад сум орон, баг орных нь мэдээллийг авч байгаад ингээд “малжуулах хөтөлбөр”-ийг улсын төсвийн тодотгол хийх замаар жоохон далайцтай хийгээд, тэгээд тэр мөнгийг малынх нь 50 хувьд нь ч юм уу өсвөр үржлийн мал өгөөд, эргээд урт хугацаандаа хүү багатай зээл байдлаар тооцоод ингээд эргүүлээд авчих тал дээр нь бид бүхэн бас нэг салбарын Байнгын хороо нэг ажлын хэсэг гаргаад энэ дээр ажилламаар байна. Тэгэхгүй бол Засгийн газраас бол дорвитой яг асуудал орж ирэхгүй байна.

Бүх хүний зээлийг тэглэх юм шиг ингээд ийм яриа гараад байна. Тэгэхээр энэ чинь ер нь бол малаа алдаагүй зүгээр энгийн өвөлжчихсөн газруудын асуудлыг бол энд яриагүй.

2 дугаарт нь, энэ малжуулах гэдэг энэ хөтөлбөр дээрээ бид бүхэн яг ярихгүй бол сая ЗГХЭГ-аас бодитой урьдчилсан тооцоолол оруулж ирлээ шүү дээ. 20 сая толгой мал хорогдох энэ чинь Монголын хувьд бол ерөөсөө гамшиг байхгүй юу. 60 сая толгой малын 3-ны 1 нь алга болох гэж байна. Дараагийнх нь байдлаар 20 мянган өрх, энэ 20 мянган өрх хөдөө малгүй бол ямар юмаа хийж хөдөө байх вэ дээ, тэгээд л хот суурин газар бараадна шүү дээ. Тэгээд нөгөө хотын сэргэлт, хөдөөгийн сэргэлт гээд хотоос хөдөө рүү шилжих хөдөлгөөн бид нар яриад байдаг. Тэгэхээр мянга яриад яах юм. 2000 оны их нүүдэл давтагдах магадлалтай болчихлоо.

Тэгэхээр хэдүүлээ салбарын Байнгын хорооны хувиар энэ асуудлыг

манлайлаад ярья. Энэ дээр бол улс төржөөд байх юм үнэндээ алга. Яг малгүй болчихсон, хотоо харлуулчихсан, 50-аас дээш хувийн хорогдолтой болчихсон хүний хүмүүсийн сэтгэл санаа хүртэл маш хүнд байгаа. Тэгэхээр энэ асуудлыг ярьж оруулах юм уу, бүр болохгүй бол хэдүүлээ Байнгын хороон дотор ярьж байгаад ажлын хэсэг байгуулаад ингээд энэ тэр бас ажиллавал яасан юм бэ гэсэн ийм санал байна.

Ж.Батжаргал: Үнэхээрийн байгаль, цаг уурын давагдашгүй хүчин зүйл бий болоод гамшигийн байдал нүүрлэчихлээ. Үүнийг дагасан хохирол юмнууд байна гэж тооцоод эрсдэлийг бууруулах, хохирлыг арилгах, сэргээн босгох үйл ажиллагаа руу чиглэсэн арга хэмжээнүүдээ авч хэрэгжүүлээд ажиллаж байгаа. Засгийн газраас сая энэ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу тодорхой авч хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээнүүдийнхээ талаар мэдээлэл юмнуудаа бүгдийг өгчихсөн. Давын өмнө зээлийн төлөлтийн хугацааг хойшлуулах тухай асуудал, түүнийг дагасан хүүгийн хуримтлалын тодорхой хэсгийг төр хариуцах тухай асуудал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны батлагдсан төсөв дотор багтааж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөрөнгийнхөө хүрээнд малгүй болж байгаа иргэдийг “малжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхлэх ийм үүрэг чиглэлүүд өгөгдсөн. Цагийн нөхцөл байдалдаа бид тов тодорхой тоон дээр, судалгаан дээр тулгуурлаж холбогдох арга хэмжээнүүдээ авч хэрэгжүүлнэ. Тийм учраас би малын хорогдол яг хэд гарав, 1.

2 дугаарт, хэчнээн өрх хамрагдав. Яг тэр улсуудтай хамааралтай асуудлыг нь бол Улсын Их Хурал, холбогдох Байнгын хороо тов тодорхой санал юмнуудаа ярина. Тийм учраас яагаа ч үгүй дүн мэдээнүүд тов тодорхойгүй байхад янз бүрийн юм яримгүй байгаа. Би бол тэгж ойлгоод байгаа юм. Тов тодорхой дүн мэдээ судалгаан дээр

тулгуурлаж авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхой болгож ярья. Энэ бол тодорхой цаг хугацаагаар тасалбар болгох ёстой зүйл байгаа юм. Тэгэхээр өнөөдөр 3 сарын 19, үндсэндээ адуу, бог малд бол нэлээн хугацаа байна. Энэ юмнуудаа нэлээн харгалзах хэрэгтэй. Тийм учраас аль болохоор хорогдол юмнуудаа бууруулах гэдэг юм уу байх чиглэлээр тэр эрсдэлийг бууруулах арга хэмжээнүүдээ авч хэрэгжүүлээд, тодорхой хугацааны ар дээр яг тодорхой цаг хугацаагаар тасалбар болгоод түүн дээр гарч ирсэн дүн, судалгаан дээрээ тулгуурлаж холбогдох арга хэмжээнүүдээ авч хэрэгжүүлэх ёстой. Ингэж ойлгож ажиллаж байгаа шүү гэдгийг та бүгдэд хэлье.

Ингээд үндсэн хэлэлцэх асуудалтай холбогдуулж санал гараагүй учраас хэлэлцэх асуудлаа тогтлоо.

Мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун хийнэ.

Х.Болорчулуун: Хаврын тариалалтын бэлтгэл ажлын явцын талаарх танилцуулга.

Монгол Улсын хэмжээнд 2024 онд 390,6 мянган га-д үр тариа, үүнээс 365,6 мянган га-д улаан буудай, 19,3 мянган га-д төмс, 15 мянган га-д хүнсний ногоо, 7,6 мянган га-д жимс жимсгэнэ, 78 мянган га-д малын тэжээл, 68,9 мянган га-д тосны ургамал нийтдээ 580 мянган га-д тариалалт хийж, 350,9 мянган га-д урини боловсруулж 546 мянган тонн үр тариа, үүнээс 515 мянган тонн улаан буудай, 225 мянган тонн төмс, 220,7 мянган тонн хүнсний ногоо, жимс, жимсгэнэ 4 мянган тонн, 195 мянган тонн тэжээлийн ургамал, 34 мянган тонн тосны ургамал, нийт тооны 1 аравны сая тонн ургац хураан авч хүн амын дотоод хэрэгцээт улаан буудай төмсийг 100 хувь, хүнсний ногооны хэрэгцээний 95 хувийг дотоодын ургацаас хангах боломжийг бүрдүүлэхээр

төлөвлөж хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Үрийн хэрэгцээ шаардлага хангамж:

Тариалалтад улаан буудайн үр 55 мянган тонн шаардагдахаас Хөдөө аж ахуйн корпорацад 7,2 мянган тонн, улсын үрийн нөөцөд 3 мянган тонн, аж ахуйн нэгж иргэдэд 40,6 мянган тонн нөөцтэй байгаа ба импортоор 9,6 мянган тонн үр орж ирэх гэрээ хийгдээд байна.

Төмсний үр 48,3 мянган тонн шаардлагатай бөгөөд Ургамал газар тариалангийн хүрээлэнд торгон үр 50 тонн, элит үр 400 тонн, вирусгүй бичил буцуу 130 мянган ширхэг байгаа ба үр шинэчлэлийг 150 га талбайд хийнэ. Үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдэд 1-2 дугаар ангиллын үр 45 мянган тонн байна. Вирусгүй бичил буцууны хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Судалгаа хөгжлийн төвд энэ инветро орчинд буцуу ургуулах лабораторийн тоног төхөөрөмж суурилуулах тариалалт хийх бэлтгэл ажлыг 23 оноос хийсэн. Үүний үр дүнд жилд 48 мянган ширхэг буцуу үйлдвэрлэж хэрэгцээнийхээ 70 хувийг хангах юм.

Хүнсний ногооны үрийн хэрэгцээг тооцвол нийт 1177 тонн үр шаардлагатай. Үүнээс 0,8 тонн шар лууван 17,6 тонн, шар манжин 2,7 тонн, хүрэн манжин, 23 тонн, төл сонгинын үр 953 тонн, саримс 181 тонн, хэмх 48 кг, лооль 4,8 кг, чинжүү 164,4, навчит ногоо 38 кило.

Улсын төсвийн хөрөнгөөр 221,5 тонн 11 төрлийн хүнсний ногооны үрийг худалдан авах гэрээ байгуулах бөгөөд нийт 2624 га талбайд тарьж 33 мянган мянган тонн ургац авна. Дэмжлэгийн үр дүн нийт үрийн хэрэгцээний 2-30 хувийг хангана.

Өвлийн хүлэмж 2 га, зуны нийлэг хальсан хүлэмжийн тариалалтыг 16 га-аар нэмэгдүүлнэ. Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн 13,7 тэрбум төгрөгөөр 5196 ширхэг нийлэг хальсан хүлэмж авах ажлыг зохион байгуулна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжих, жимс жимсгэнийн дотоод хангамжийн хувийг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвийн 980 сая төгрөгт Төв, Хэнтий, Увс аймгуудад, Нийслэлийн БЗД-т чанарын шаардлага хангасан нутагшсан сортын жимс, жимсгэний суулгац үржүүлгийн төв 12 га-д байгуулна. Жижиг дунд үйлдвэрлэлийн сангаас 2,8 тэрбум төгрөгийн зээлийг хангалттай нөхцөлөөр олгох ажлыг хэрэгжүүлнэ.

Санхүүгийн дэмжлэг бол ургамал хамгааллын бодис, бордоо, шатахуун, техник тоног төхөөрөмжийн бэлтгэл ажил.

Энэ Засгийн газрын хуралдаанд улаан буудайн үрийг 30 хувь, төмс, хүнсний ногооны үрийг 80 хувь, бордоо оны татаасыг 30 хувь хүртэл олгох шийдвэрийн төслийг бэлтгэж танилцуулна.

Улсын төсвийн 4,4 тэрбум төгрөгт хөрсний үржил шимийг сайжруулах, ургац нэмэгдүүлэх зорилгоор бордоо хэрэглэсэн хуулийн этгээдэд хөнгөлөлт үзүүлэх, төмсний хүнсний ногооны механикжуулалт 3,9 тэрбум төгрөгийн үнийн хөнгөлөлт олгож, 950 га-г механикжуулна.

Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн эргэлтийн хөрөнгө сайжруулах зээлд 2024 онд 65 тэрбум, хүнсний ногооны үйлдвэрлэлд 16 тэрбумыг тус тус жилийн 6 хувийн хүүтэй, 24 сарын хугацаатай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээнд анхан шатны үр үржүүлгийн төв, үтрэм байгуулахыг дэмжихэд 8 тэрбум,

хүлэмжийн аж ахуй байгуулахад 7 тэрбум, зоорины аж ахуй байгуулахад 10 тэрбум төгрөгийг тус тус жилийн 6 хувийн хүүтэй 48 сарын хугацаатай зээлийг олгох мэдээллийг тариаланчдад хүргэж, хүсэлт ирүүлсэн материалыг цахим системд хянаж, арилжааны банканд хүргэж, бодлогын гэрээ байгуулан ажиллаж байна.

Улсын хэмжээнд 6,3 тэрбум төгрөг Сэлэнгэ, Төв, Дархан, Булган, Орхон, Хэнтий, Дорнод аймгууд 1310 км-т хөрс хамгаалах арга хэмжээ зохион байгуулна.

Хүнсний ногооны хадгалалт, хамгаалалт, улирлын хамаарлыг бууруулах зорилгоор улсын төсвийн 13,5 тэрбум төгрөгөөр Сэлэнгэ аймгийн Орхон мандал, Баянгол, Шаамар, Хушаат, Жавхлан, Зүүнбүрэн сумдад баригдах 200-500 тонн төмс, хүнсний ногооны зорь барих ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулаад байна.

Энэ онд бордоо 20 мянган тонн, ургамал хамгааллын бодис 1980 тонн тус тус шаардлагатай. Бордоо импортлох хүсэлтэй 15 аж ахуйн нэгж ОХУ, Хятад улсын үйлдвэрүүдтэй 9 мянган тонн орчим худалдан авах гэрээ байгуулсан бөгөөд ГЕГ-ын мэдээгээр эхний 3 сарын байдлаар 10 аж ахуйн нэгж 2200 тонн бордоо импортлоод байна. Ургамал хамгааллын бодис импортлох тусгай зөвшөөрлийг 33 аж ахуйн нэгж 2346 тонн импортлох хүсэлт ирүүлснийг судалж, хянаж зөвшөөрлийг олгоод байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлд 23 мянган тонн шатахуун хэрэгцээтэй ба тариалалт, урини боловсруулалтад 11 мянган тонн, ургац хураалтад 12 мянган тонн шаардагдах тооцоог гаргаж холбогдох мэргэжлийн байгууллагад албан ёсоор хүргүүлсэн.

Тариалалт, урини боловсруулалтын ажилд трактор 3900 ширхэг, үр тарианы үрслүүр 2820 ширхэг, төмс, хүнсний ногооны үрслүүр 550 ширхэг, хөрс боловсруулах техник 4850 ширхэг ажиллана. Мөн улсын төсвийн хөрөнгөөр тариаланд ашиглах боломжтой атар болон атаршсан газрын хэмжээ тогтоох судалгааг Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгууд, төвийн бүсийн 5 аймгийн 43 сумд, зүүн бүсийн 3 аймгийн 5 сумд тариалангийн газрын төлөв байдал, хөрсний үржил шим, элэгдэл, эвдрэлийн үзүүлэлтийг шинэчлэх бордооны нормын хэмжээг тогтоох, тариалангийн талбайн хөнөөлт организмын тархалт, зүйлийн бүрэлдэхүүн тогтоох судалгааг Баруун бүсэд 45 мянган га-д, хүнсний хүн амын хэрэглэж буй импортын болон дотоодын үйлдвэрлэлийн хүнсний ногоо, жимс, жимсгэнэд пестицид, нитратийн үлдэгдэл тодорхойлох тандалт судалгаа хийнэ.

Тариалангийн тухай хуулийн хэрэгжилт, үр дагаврын үнэлгээг хийх замаар хуулийн хүрээнд анхаарах асуудал, цаашидын баримтлах бодлогыг тодорхойлох боломжийг бүрдүүлнэ.

Мөн 2024 онд цаг уурын нөхцөл байдалд тохирсон хаврын тариалалтад баримтлах технологийн ерөнхий зөвлөмжийг боловсруулахаар мэргэжлийн эрдэм шинжилгээний хүрээлэн, эрдэмтэдтэй хамтран ажиллаж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Батжаргал: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Болорчулуун сайд, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн дарга Оюунсүвд, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Цолмонжаргал нар оролцож байна.

Хийсэн мэдээлэлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Тасаллаа. Дамдинням гишүүн асуултаа асууя.

Г.Дамдинням: 2024 оны хаврын тариалалтын бэлтгэл ажлын явцын талаарх танилцуулгыг сонсож байна. Тэгээд 2 асуулт байна.

1 дүгээрт, энэ ОХУ-д болж байгаа нөхцөл байдалтай хамаараад манай энэ дизель түлшний асуудал нэлээн бэрхшээлтэй болоод өнгөрсөн. Одоо жил бид нар нэлээн л асуудалтай байгаад дууслаа. Тэгээд Засгийн газар дээр та бүхэн маань ер нь ямархуу бэлтгэл хангаж байгаа вэ? Яг энэ хаврын тариалалтын үетэй давхардаад энэ өвлийн түлш, зуны түлш 2-ын шилжилт явагдана.

Дээрээс нь уул уурхайн идэвхжил ид явагдана. Тэгэхээр ер нь манай хамгийн их дизель түлш хэрэглэдэг цаг болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр та хэд маань ер нь ямархуу нөхцөл байдлыг шийдэж байгаа юм. Аж ахуйн нэгжүүдтэй уулзаад явж байхад үнэтэй ч хамаагүй энэ евро 5 Хятадаас авъя гэдэг асуудал яриад байгаа юм байна лээ. Оросоос ч гэсэн авдгаараа л авна, мэдээж. Тэгээд энэ урд Замын-Үүд дээр энэ дамжуулан ачуулах төвийнх нь хэмжээ хязгаарт багтдаггүй болчихоод юм орж ирдэггүй гэсэн бас ийм мэдээллүүд яваад байдаг. Тэгээд энэ бэлтгэл ажлаа ер нь яаж хангаж байгаа вэ, 1.

2 дугаар асуудал. Одоо ингээд бид нар нэг хавар ингээд буужигнаж байгаад л нэг юм тариалалтаа хийгээд дуусна. Тэгэнгүүт манай Дархан-Уул аймгийн Орхон сум, Төв аймгийн Жаргалант сум гээд энэ хүнсний ногоо тариалдаг газруудад ер нь бол энэ чинь төмс, хүнсний ногооны хамаг дийлэнхийг л гаргаж байгаа 2 төв шүү дээ. Монголын. Үер усны аюул нүүрлэнэ, зун. Ялангуяа энэ УЦУОШГ-аас авч байгаа мэдээллээр

энэ жил бол асар их хэмжээний хур бороотой байна л гэсэн ийм мэдээлэлтэй байгаад байна. Тэгэхээр энэ ногоочдыг, тариачдыг даатгуулах, энэ гамшигийн нөхцөл байдлаас хамгаалах бэлтгэл ажил ер нь ямар түвшинд яваа вэ? Дууссан хойно нь тэгээд л УОК гээд л, дахиад л баахан бужигнаад л. Тэгээд л хөөрхий уржнан жил гэхэд их томоохон хэмжээний үер Төв аймгийн Жаргалант, Дарханы Орхон тэр хавиар ингээд болсон. Маш олон ногоочид, тариаланчид хөөрхий минь үерт өртсөн. Ингээд нөгөө хүмүүс нь онцгой нөхцөл байдлаас авдаг энэ төлбөр хураамжийг авъя гэхээр зэрэг өгдөггүй. Яагаад гэвэл энэ онцгой байгалийн гамшигт нөхцөл биш байна гэсэн ийм асуудал тавиад өгөөгүй. Даатгалд хамруулах гэхээр банкнуудын баахан зээлд орчхоод нөгөө талдаа даатгалд хамрагдаж өгдөггүй ийм асуудал байгаа. Би үүнийг өмнө нь 2, 3 ч удаа энэ Байнгын хорооны хурал дээр ярьж байсан. Тэгээд ямархуу ахицууд гарсан сан бэ? Энэ 2 асуултад хариулж өгөөч.

Ж.Батжаргал: Хариулъя.
Болорчулуун сайд.

Х.Болорчулуун: Дамдинням гишүүний асуултад хариулъя. Энэ хавар түлшний хангамж байдал ямар байх вэ гэж байна. Өнгөрсөн намар та бүхэн мэдэж байгаа дөнгөж хураалт эхэлж байхад нэг литр түлшний үнэ 2450 байснаа хураалтын дундуур төгсгөлд нь 3500-3700 болсон. Энэ ингээд газар тариалангийн ялангуяа улаан буудайн үнэ өртөгт шингээд л явчхаж байгаа юм л даа. Ер нь нэг хэсэг намар түлши тасалдсан. Гэхдээ юу, манай бол Уул уурхайн яам Ганбаатар сайд ОХУ-д бүр очиж гэрээ хэлцэл энэ тэр хийсэн. Ер нь бодлогын хэмжээнд бол Оросын холбооны бас дизель түлшээ нэлээн орнуудад хязгаарлалтыг хийсэн, өөрийн дотоодын бас нэг хангамж хүртээмжтэй холбоотой гэж байгаа юм. Тэгэхдээ Монгол Улсыг дизель түлшний хязгаарлалтад оруулахгүй

гэдгийг бас албан ёсоор мэдэгдсэн байгаа. Тэгэхээр энэ хавар түлши тасалдах асуудал гарахгүй гэсэн ийм төсөөлөлтэй, төлөвлөлттэй байна л гэж хэлэх байна.

Хүнсний ногоо тэр Дарханы Шарын голд бас тариа нэлээн их тариалдаг. Өнгөрсөн жил бол 200 гаран 250-аад га-д үерт автчихсан байгаа. Үүнийг бол бас Дархан аймгаас сонгогдсон та гишүүдийн бас саналыг харгалзаад бас саналыг авч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам дээр бол тэр зээлийг бол хойшлуулсан байгаа шүү, 1 жилээр хойшлуулсан байгаа. Тэгэхээр хөнгөлөлттэй зээл авсан байгаа тэр зээлийг нь 1 жилээр хойшлуулсан байгаа гэдгийг хэлье. Дахиад энэ жил заавал үерт автах ёстой ч юм уу, автах боломжтой гэж хэлж бас болохгүй. Ер нь үер хаагуур орж ирсэн яаж тэрийгээ хамгаалахыг бас аж ахуйн нэгжүүд тэр тариаланчид бас өөрсдөө бас хийх ёстой гэдгийг бас хэлэх байна.

2 дугаарт, газар тариаланг энэ даатгалын компаниуд ер нь даатгадаггүй шүү дээ. Яагаад гэвэл эрсдэлтэй. Үндсэндээ газар тариалан, ногоо ч тэр, тариа ч тэр голио шиг л азаа үзээд л тариа ногоогоо тарьж байгаа. Тэгэхээр албадан даатгалын систем бол байхгүй, энэ хуучин социализмын үе шиг. Ингэхээр яг газар тариалан даатгуулах болохоор бас хувь нь өндөр байдаг юм билээ. Түүнээс болоод газар тариаланчид даатгуулдаггүй. Ерөнхийдөө даатгалын компаниуд даатгах сонирхолгүй байдаг гэдгийг хэлье.

Ж.Батжаргал: Болсон уу.
Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Хаврын тариалалтын бэлтгэл ажлын явцын талаарх танилцуулгатай бас танилцлаа.

Тэгээд 6,3 тэрбум төгрөгөөр Сэлэнгэ, Төв, Дархан, Булган, Орхон,

Хэнтий, Дорнод аймаг дээр 1310 км газарт хөрс хамгаалах юм байна. 13,5 тэрбум төгрөгөөр Сэлэнгэ аймгийн Орхон, Мандал, Баянгол, Шаамар, Хушаат, Жавхлан, Зүүнбүрэн сумдад 200-500 тоннын хүнсний ногооны зоорь барих юм байна. Мөн 4,4 тэрбум төгрөгөөр хөрсний үржил шимийг сайжруулах юм байна. Жижиг, дунд үйлдвэрлэлийн сангаас 1 2,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгох юм байна. Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад бас энэ судалгааны ажлыг бас хийх юм байна гээд зөндөө ажлуудыг бас тавьсан юм байна. Төв аймаг, Хэнтий, Увс аймагт ч тэгсэн 980 сая төгрөгөөр бас энэ жимс, жимсгэнийн энэ дотоодын хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвөөс жимс тарих юм байна гээд.

Яг говьд яг юу хийгдэх юм бэ? Говьд. Тэгээд энэ 2 га газарт өвлийн хүлэмж барих юм байна. Мөн 5196 ширхэг зуны хүлэмж 13,7 тэрбум төгрөгөөр худалдаж авах юм байна. Яг энэ говьд юу гэдэг юм, өвлийн хүлэмжийг тарих, зуны хүлэмжийг олгох ийм бололцоо боломж бас байгаа юм уу. Нэг жилийн жилд л энэ нэг тариалалтын асуудлыг ингээд л ярихаар манай говийн бүс ингээд хаягддаг л даа. Ялангуяа манай Дорноговь аймгийн бүс нутаг байна. Өмнөговь аймаг, Дундговь аймаг, Говьсүмбэр аймаг гээд. Тэгээд хүлэмжийн аж ахуй бол эрхлэх бололцоо боломжтой газар бол ерөөсөө л говийн бүс гээд судалгаагаар гарчихсан байдаг юм байна лээ шүү дээ. Нэг жилийн өмнө, 1 сарын өмнө тариалалтаа эхлэх бололцоо боломжтой. 2 сарын дараа тариалалтаа хураах бололцоо боломжтой гээд. Тэгээд 1 тариалалтын асуудал ярихаар л манай говийн бүс ингээд хаягддаг.

Тэгээд Монгол Улсын төсөвт орж байгаа мөнгийг бодохоор Монгол Улсын экспортын 90 хувийг говь хийдэг. Импортын 80 хувийг манай говь бүрдүүлдэг. Монгол Улсын валютын

орлогын 49 хувийг говь бүрдүүлдэг. Монгол Улсын нийт төсвийн орлогын бараг 40 гаруй хувийг зөвхөн говиос бүрдүүлж байдаг. Тэгээд 1 газар тариалангийн асуудал ярихаар л, хүлэмжийн асуудал ярихаар л манай ингээд говь хаягддаг. Говь. Тэгэхээр энэ говьд яг юу оногдож байгаа юм? Энэ зуны хүлэмж олгогдох юм уу, өвлийн хүлэмж олгогдох юм уу? Энэ газар тариалангийн энэ усалгааны систем, трактор комбайн олгох тийм зүйл байгаа юм уу? Яг ингээд танилцуулгыг хараад байхад ихэнх аймгууд бол нэр усаараа орсон байна л даа. Яг манай говийн бүс дээр бол юу ч алга байна шүү дээ.

Тэгэхээр говьд яг хэчнээн хүлэмж оногдох юм, өвлийн хүлэмж баригдах юм уу, баригдахгүй юм уу. Ер нь газар тариалангийн чиглэлээр ямар бодлого барьж байгаа юм. Цаашидаа энэ говийн бүсийг яаж тэр хүлэмжийн аж ахуй эрхлэх бололцоо боломжийг нь бий болгох талаар Хүнс, хөдөө аж ахуйн яам барьж байгаа юм. Энэ тал дээр нэг хариу хэлж өгөөч, та. Тэгээд энэ 2 га газарт энэ өвлийн хүлэмж барих юм байна. 5196 тэр зуны хүлэмжээсээ говьд яг хэд нь оногдох юм бэ? Үүнийг тодорхой бас хэлж өгөөч, та. Манай говьд юу гэдэг юм, өвлийн хүлэмжийг ашиглаад явах бололцоо боломж байж байна. Өрхийн аж ахуй эрхлээд явах бололцоо боломж байж байна. 40-50 насны иргэд маань юу гэдэг юм, хүнсний ногоо бас тариалаад явах бололцоо боломж бүрэн байгаад байна шүү дээ. Тэгээд энэ дээр та ямар бодлого барьж байгаа вэ?

Ж.Батжаргал: Хариулъя.
Болорчулуун сайд.

Х.Болорчулуун: Энэ говийн аймгууд хүнсний ногоо тариалахад дулааны хангамж бол хүрэлцээтэй. Ийм хамгийн боломжит аймгууд л даа. Гэхдээ энэ дээр тавигдсан энэ тооны 5196 ширхэг нийлэг хальсан хүлэмжийг улсын болон төсвийн орон нутгийн хөрөнгөөр

барина гэж 13,7 тэрбум, энэ бол дийлэнх нь нөгөө гишүүдийн “шинэ хөдөө” төслийн хүрээнд тавигдсан мөнгө байгаа гэдгийг хэлье.

Танай аймгийн гишүүд хэр тавьсан юм, тэрийг бол мэдэхгүй. Нарийн мэдээллийг Оюунсүвд Газар тариалангийн газрын дарга хариулж өг дөө.

Ж.Батжаргал: Оюунсүвд ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Н.Оюунсүвд: Би хариу хэлье. Ер нь Дорноговь, Өмнөговь аймгууд өөрсдөө орон нутгийн төсвөөрөө хүлэмжийн аж ахуйг нэлээн сайн эрхэлдэг. Яагаад гэвэл нөгөө уул уурхайгаас орон нутгийн төсөвт нэлээн орлого ордог учраас ямар нэгэн тийм санал ирдэггүй. Энэ бол яг 5116 хүлэмж бол Булган аймаг, Дорнод аймгийн “шинэ хөдөө” төслийн хүрээнд авагдах ийм хүлэмжүүд байгаа. Говь аймгуудад харин бид нар юу хийх гэж байна вэ гэхээр төмсний үрийн шинэчлэлийг хийж өгнө. Мөн 11 төрлийн хүнсний ногооны үрийн хуваарилалтыг орон нутгаас нь өөрсдөөс нь санал асуухад яг жилд урьд жил нь тарьж байгаа тариалалтын хэмжээг нь харж байгаад саналыг нь харгалзаж байгаад боломжоороо яг л өөрсдийнх нь хүссэн хэмжээгээр нь өгдөг байгаа.

Ж.Батжаргал: Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

Т.Энхтүвшин: Ер нь яах вэ, ингээд нэг, говийн бүс ингээд өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг, төсвөө өөрөө бүрдүүлдэг гээд бүхий л юмнаас ингээд л хоцроод л байдаг юм л даа. Ер нь тэгээд Монгол Улсын төсвийг 40 гаруй хувийг л говийн бүсээс бүрдүүлж байна шүү дээ. Та бидний авч байгаа цалингаас эхлүүлээд, барьж байгаа сургууль, цэцэрлэгээс эхлүүлээд, энэ өгч байгаа трактор комбайн, газар тариалангийн багаж, тоног төхөөрөмжөөс эхлүүлээд. Тэгэхээр өөрсдөө бид нар санаачилга

гаргаад энэ төсөв бүрдүүлж байгаа аймаг дээрээ ч тэгсэн та хэд маань бас тавьж өгвөл улам бас илүү л их говийн ард иргэд бас нэлээн баярлах болов уу л гэж боддог юм. Зүгээр одоо иргэд маань юу гэж ярьдаг гэхээр ерөөсөө яамнууд бид нарыг анхаарахгүй байна. Ялангуяа энэ газар тариалангийн чиглэлээр, усны чиглэлээр бид нар ерөөсөө анхаарахгүй байна, бид нарыг дэмжихгүй байна.

Ж.Батжаргал: Санал байна.

Ганболд гишүүн асуулт асууя.

Г.Ганболд: Хоёрхон асуудал байна. Би бас л энэ хаврын тариалалттай холбоотой энэ дизель түлш дээр л санаа зовоод байна. Өнөөдөр ОХУ хэдийгээр манайх хязгаарлалт тогтоохгүй гэсэн ч гэсэн энэ дайны нөхцөл байдал чинь ерөөсөө Украйны тал бол Оросын бүхий л нефтийн үйлдвэр лүү чиглэж байна шүү дээ. Өдөрт л бараг нэг Нефтийн үйлдвэрлэлд цохилт өгч байна. Дроны. Одоо бүр 2000 км-ийн цаана алслалтай нефтийн үйлдвэрт хүртэл цохилт өгч байна шүү дээ. Энэ агуулгаараа бол ОХУ дотоодын энэ нефть бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь 15 гаран хувиар уначихлаа гээд мэдээллүүд байнга явж байна. Үүнтэй холбоотой цаашидаа ингээд байнга үргэлжлэх юм бол тэрэнд бид нар ямар ч найдах боломжгүй болж байгаа магадлал гарахыг үгүйсгэхгүй. Тэгэхээр зэрэг Хөдөө аж ахуйн корпорацад байдаг нөөцийн савнууд маань дотроо юм байна уу, үгүй юү? Хэрэв хоосон байгаа бол тэр хэдэн мянган тоннын нөөцийн сав байна. Тэрийг бас нэг арай гайгүй байгаа дээр нь дүүргэж нөөцөлж авах тал дээр төсөвлөсөн хөрөнгө, түүн дээр анхаарч байгаа зүйл байна уу. Үүнийг бас нэг Засгийн газрын хуралдаан дээр энэ бол Уул уурхайн сайд, Хөдөө аж ахуйн сайд эд нар яаралтай ярьж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байхгүй бол нэг өдөр л таг зогсохыг бид нар үгүйсгэх аргагүй. Ийм эрсдэлтэй нөхцөл байдалд байгаа шүү. Энэ дээр онцгой анхаарал

хандуулахгүй бол хавар маш эрсдэлтэй нөхцөл үүсэх магадлалтай.

2 дугаарт нь, бид нар сая цас зуд гээд түрүүхэн яриад зогсож байна. Тариалалтын бэлтгэл ажил гэхээр ерөөсөө бид нар энэ улаан буудай, төмс, хүнсний ногоо чиглэл рүүгээ л түлхүү яриад байдаг. Малын тэжээлийн үйлдвэрлэлийн дэмжлэг гэж ерөөсөө энэ дээр бараг байхгүй байна. 78,3 мянган га-д малын тэжээл тариална гэж байна. Яг эндээс энэ тариалалтын бэлтгэл ажлын явцад малын тэжээл тариалалт дээр яг ямар дэмжлэг байгаа вэ? Яамнаас, Хөдөө аж ахуйн корпорацаас. Ерөөсөө хамгийн гол юм бол энэ жил энэ малын тэжээл тариалсан одоо Өвөрхангайн Хархорин сумд гэхэд энэ малын тэжээл тариалалтаар бас би энэ өнгөрсөн жил Болорчулуун сайдад хүсэлт тавьж байгаад энэ Хөдөө аж ахуйн корпорацын мэдэлд байдаг газрыг сумынх нь иргэдэд, багуудад, аж ахуйн нэгжүүдэд хуваарилсны үр дүнд тэнд тарьсан 1 мянга гаран га-д тарьсан ногоон тэжээл маш их хэмжээний дэмжлэг үзүүлсэн. Үнийг буулгасан. Тухайн үедээ ногоон тэжээл 9, 10 мянга л байсан. Тэгээд энэ чиглэл рүү цаашидаа бид нар энэ малын тэжээлийн үйлдвэрлэлийнхээ тариалангийнхаа газрыг нэмэгдүүлэх ёстой юм байна.

Нөгөө талаар энэ корпорацаас ер нь яамнаас энэ үр тариануудыг аж ахуйн нэгжүүдтэй адилхан тэд нарт дэмжлэг үзүүлдэг, оронд нь ер нь цаашидаа энэ улсын нөөцийн өвс тэжээлийн нөөцөө энэ салбарын яам нь, энэ Хөдөө аж ахуйн корпорац нь бэлдээд яг энэ үр тарианыхаа эргэлт шиг өгсөн үрэндээ ногоон тэжээлээ авч нөөцлөөд, хүндэрсэн газруудаа буцааж зарж энэ эргэлтэд оруулдаг. Нөгөө талаараа үүгээр энэ хавар өвс, тэжээлийн үнэ өсөх энэ эрсдэлээс хамгаалдаг ийм л тогтолцоо руу орохгүй бол бид нар энэ ган зудын энэ эрсдэлээс бид нар хэзээ ч гарахгүй юм байна. Тэгэхээр энэ чиглэлээр сайд бас энэ жилийн яг энэ төлөвлөсөн юмнууд дотор ямар

хөрөнгүүд байна гэдгийг асуух гээд байна.

3 дугаарт нь, энэ жил энэ газар тариалан үйлдвэрлэгчийн эргэлтийн хөрөнгөөр 24 онд 65 тэрбум төгрөг, хүнсний ногооны үйлдвэрлэлд 16 тэрбум төгрөгийг 5 хувийн хүүтэй өгөх нь ээ. Энэ хүрээнд энэ 65 тэрбум төгрөгөөс ... /минут дуусав/

Ж.Батжаргал: Ганболд гишүүний микрофоныг 1 минутаар сунгачихъя.

Г.Ганболд: Энэ хуваарилагдаж байгаа хөрөнгөөс малын тэжээл тариалалтад аж ахуйн нэгжүүдэд зориулж хөнгөлөлттэй, хүү багатай энэ зээлийг бас үүнийхээ тодорхой хувийг тусгаж хуваарилах ийм боломж байгаа юу? Ингэж явж байж бид нар бас нэг хагас хугас энэ мал аж ахуйн салбарынхаа эрсдэлээс гарах ийм боломж байна. Үүнийг бид нар ер нь олон жил хаяж явж зудын дараа нэг хаширна, тэгээд л мартчихдаг. Зудын эргэлт нэг 10 жил тутам явж байна. Тэгээд 1 хэдэн жил яах вэ, мал нь цөөрчихөөр сайндаа ч биш л дээ. Зудад баахан мал нэрвэгдэхээр бэлчээрийн даац нь нэг арай гайгүй болоод л тэгээд жаахан тоо толгой нь өсөж байгаад л буцаад тоо толгой нь нэмэгдээд ирэнгүүт дахиад л 10 жилийн хугацаатай дахиад л зуд болдог, тэгээд л нэг хаширдаг. Тэгээд ийм л байдлаар явсаар байгаад энэ чинь тогтолцоо ерөөсөө байхгүй болчихоод байна шүү дээ. Тэгээд энэ чиглэл рүү бас яамнаас тодорхой гаргаж байгаа бодлого чиглэл байна уу?

Ж.Батжаргал: Хариулъя. Болорчулуун сайд.

Х.Болорчулуун: Ганболд гишүүний асуултад хариулъя. Энэ жилийн өвлийн байдал бол бэлчээрийн мал аж ахуй зөвхөн өвсөө бэлтгээд, хадлангаа бэлтгээд болохгүй нь ээ гэдгийг бас

харуулаа. Бэлчээрээр мал сүргээ зөвхөн хариулах нь учир дутагдалтай байна гээд харуулсан л даа. Тийм учраас ногоон тэжээл, малын тэжээл тарих нь бол зайлиггүй чухал. 22 оноос 23 онд бол ногоон тэжээл тарих явдал 46 хувиар өссөн юм. 24 онд бол бүр их өснө. Ялангуяа малчид хоорондоо хоршиж ногоон тэжээл тариалах ажлыг бол санал нэгтэй ярьдаг боллоо. Үүнийг ч бас хоршооллын дэмжих байдлаар Засгийн газрын зүгээс тодорхой хэмжээний зээл дэмжлэгийг үзүүлбэ гэсэн ийм чиглэлтэй ажил эхлээд байгаа.

Ногоон тэжээл тарихад үр хамгийн чухал. Үрийг өнгөрсөн жил ногоон тэжээл тарих аж ахуйн нэгжүүдэд, хүмүүст, иргэдэд 30 хувийн урьдчилгааг нь аваад, 70 хувийг нь сүүлд нь авахаар жилийн хугацаатай ийм гэрээ байгуулж өгсөн. Тэгэхээр яг түүн шигээ бас үрэн дээр бол зээлийн бодлогоор энэ жил бас ажиллана. Түүнээс гадна газар тариалан эрхлэгчдийн хүнсний хангамж аюулгүй байдлын 36 дугаар тогтоолын хүрээнд 6 хувийн хүүтэй зээл байгаа. Эндээсээ бас ногоон тэжээл аваад тарих, ногоон тэжээл тарихад хэрэглэх боломжтой гэдгийг бас хэлэх байна.

Өшөө нарийн мэдээллийг юу Оюунсувд хариулаадах.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон Оюунсувд нэмэлт хариулт.

Н.Оюунсувд: Малын таримал тэжээлийн үр үйлдвэрлэл дээр 2,8 тэрбум төгрөг байгаа. Энэ Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийн газраас зарлаж авна. Энэ тэгэхээр бас хугацаандаа нийлүүлэгдэх байх. Мөн дээр нь Хөдөө аж ахуйн корпорац дээр яг одоогоор овъёосны үр, царгасны үр байгаа. Үүнийхээ урьдчилгааг 30 хувийн урьдчилгаатай 1 жилийн хугацаатай олгож болно гэсэн энэ нөхцөлөө хийсэн байна.

Дараагийн нэг асуултад нэмж хариулахад эргэлтийн хөрөнгийн 65 тэрбум төгрөг дотор малын тэжээл үйлдвэрлэл, үр, тэгээд нөгөө тэжээлийн техник, тоног төхөөрөмж авах гэдэг дээр тодорхой хэмжээний хөрөнгө санхүүжилт бас тавигдсан. Бид нарт бас санал ирээд, одоо би танд яг аваад өгье. Энэ 65-ынх нь 10 тэрбум дунд ... /минут дуусав/

Ж.Батжаргал: Танд нэмэлт асуулт бий юу?

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж санал хэлэх гишүүд нэрсээ өгье. Надад тодорхой нэг 2, 3. Ганболд гишүүн.

Г.Ганболд: Би сая нөгөө нэг асуултад бас хариулт авч чадсангүй л дээ. Би нөгөө нөөц нь бензин түлшний нөөц бэлдэх тал дээр л анхаараад байгаа юм. Тэгээд хэдүүлээ бас урьдчилж ярьж энэ би Болорчулуун сайдыг Засгийн газрын хуралдаанд санал болгож энэ Уул уурхайн сайд эд нартай нийлж байж ер нь бол Засгийн газрын нөөц хөрөнгөөс хөрөнгө гаргаж бэлдэх нь зөв шүү. Тэгэхгүй бол тэгж байгаад хавар нэг тариалалтын үед таг хийгээд зогсчих юм бол энэ сонгуулийн өмнө юун саяын энэ гурилын үнэ битгий хэл, юм болно шүү дээ. Тэгээд улсаараа зогсоно. Тэгээд ер нь нэг анхааруулаад энэ Байнгын хорооноос ч юм уу, тэмдэглэлээр бас Засгийн газарт нэг ядаж тэр нөөцийн тэр сав нь нэг 5 мянган тонн юм байна шүү дээ. Тэрийгээ ч болтугай нэг дүүргээд авчих юм бол энэ хаврын тариалалтын ядаж нэг 1 сарын салбарынх нь түлшний асуудал байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр тэмдэглэлээр үүрэг чиглэл өгч болдог болов уу, болохгүй больчих луу. Тийм. Тэгэхээр энэ дээр ямар байдлаар Засгийн газарт харилцах ёстой билээ. Энэ дээр нэг Байнгын хорооны дарга анхаарна биз.

Ж.Батжаргал: Хаврын тариалалтын бэлтгэл ажлынхаа мэдээллийг сонслоо. Бас тодорхой цаг хугацаандаа технологийнхоо хугацаанд хийгдэх ёстой ажлууд хийгдээд ингээд явж байна. Анхаармаар асуудлууд бий.

Сая энэ хурлын өмнө Төсвийн байнгын хороотой хамтарч хуралдсан хуралдаан дээр тодорхой асуудлууд яригдсан. Энэ бол яах аргагүй манай тариаланчдын бүтээгдэхүүний үнийн асуудалд ч манай хэрэглэгчдийн хэрэглэж байгаа гурил, гурилан бүтээгдэхүүний үнийн асуудалд ч нэлээн том нөлөө үзүүлээд байгаа учраас тодорхой хэмжээгээр энэ гурилын үнийг тогтворжуулах, хангалтыг нэмэгдүүлэх хүрээнд асуудал яригдсан. Тийм учраас манай газар тариалангийн үйлдвэрлэлийн хүрсэн түвшин, дэвшигдэж байгаа зорилтоосоо бид ухраагүй ээ.

Тийм учраас хаврынхаа тариалалтын бэлтгэл ажлыг бүрэн хангаад, дэвшүүлсэн зорилтынхоо хүрээнд тариалалт, үйл ажиллагаагаа явуулаад, мэдээж орцыг нээж байгаа бол бид гарцыг давхар нээнэ. Тийм учраас намрын ургац хураалтаас өмнө хурааж авсан газар тариалангийн бүтээгдэхүүнээ борлуулах зах зээлээ өргөтгөнө гэдгийг зориуд хэлэх ёстой. Ингэж байж хэдүүлээ энэ газар тариалангийн үйлдвэрлэлийн бараг 100 жил, яг аян өрнүүлсний бол 65 жил нь энэ жил байгаа байх. 1959 онд атрын анхдугаар аяныг өрнүүлсэн. 2024 он гэхээр 65 жилийн ой нь болж байгаа. Тийм учраас ямар ч байсан бид энэ бие даасан шинжлэх ухааны үндэслэлтэй салбарыг цааш нь улам ахиулан хөгжүүлэх тухай асуудал руугаа Улсын Их Хурал, Засгийн газар, мэдээж манай газар тариалангийн салбарын аж ахуйнууд хамтдаа зүтгэнэ гэдгийг би зориуд тэмдэглэж хэлмээр байна. Сайдыг ч би энэ талаасаа ажил асуудалдаа хандаж тодорхой манай газар тариалангийн салбарын хамт олонтойгоо илүү үр дүнтэй ажиллана

гэдэгт би итгэлтэй байгаа гэдгийг хэлмээр байна.

2 дахь гол зүйл бол бидэнд үрийн асуудал байгаа юм. Тэгэхээр баталгаат үрийн асуудал байгаад байна. Бид нарын энэ ургацын нэгжээс авч байгаа ургацын хэмжээ өсөж өгөхгүй байгаа. Хураасан ургац тодорхой дараагийн шатын боловсруулах салбарынхаа стандартыг хангаж өгөхгүй байгаа тэр явдал бол байгаль цаг уураас гадна бидний энэ үрэнд байгаад байгаа юм. Тийм учраас энэ хаврын тариалалтад бэлэн хангагдчихаад байгаа тэр аж ахуйнууд дээр байгаа 40 мянган тонн үрийн хянан баталгаа хэрхэн хийгдсэн бэ гэдэг зүйлийг анхаарч энэ тариалалтын хугацаанаас наана үүнийг нийцүүлэх тухай асуудлыг онцгой анхаарч ажиллах ёстой шүү гэдгийг хэлье, нэг.

2 дугаарт, импортоор орж ирэх үрийнхээ чанарт онцгой анхаарч ажиллах ёстой. Ер нь бол бид үрийн шинэчлэл хийх гэж байгаа учраас супер элит, элит үрүүдийн асуудал дээрээ л илүү гол анхаарал төвлөрч ажиллах ёстой шүү гэдгийг зориуд би хэлмээр байна.

Малын тэжээлийн ургамлын үрийн асуудал дээр бид онцгой анхаарах ёстой. Энэ чинь бид нар үр үржүүлгээр явж байгаа юм нь бага, үндсэндээ бүтээгдэхүүн хураах хэлбэрээрээ яваад байгаа учраас жилээс жилд яг малын тэжээлийн ургамлын үрийн хэрэгцээ бол нэмэгдээд явах ёстой. Үүн дээрээ онцгой анхаарал хандуулж, энэ малын тэжээл ургамлын үр хангалтыг нэмэгдүүлэх ёстой. Дан дамаа энэ малчид өөрсдийнхөө өвөлжөө бууц дээр бага хэмжээний ногоон тэжээл тариалаад хураагаад байгаа энэ сайн арга туршилагыг ер нь бүх нийтийн үйлс болгож үүнд шаардлагатай үрийн хангалтынх нь асуудлыг бас аймаг, орон нутгийнхаа Хөдөө аж ахуйн газруудтай хамтарч шийдэх ёстой шүү. Энэ бол энэ мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг малчны хотонд бүрэн

хангуулж байж л бид эрсдэлийг хохирол багатай давна гэдэг энэ том зарчмаа бодож, анхаарч ажиллах ёстой гэдгийг зориуд хэлмээр байна.

Дараагийн нэг зүйл бол энэ зээлийн асуудал байгаа юм. Одоо бид хэд яриад байна. Энэ 65, 14, 8, 7 энэ тэр гээд. Энэ зээлүүд ер нь 4 сарын 15 гэхэд аж ахуйнуудтайгаа бүгд гэрээ хийгдээд олгогдох түвшиндээ очих ёстой шүү. Өмнөх он жилүүдийн нэг дутагдал бол зээл тариалалтын ажил эхэлж байхад олгогдоогүй байснаас холбогдоод технологийн цаг хугацаа хоцорч үйлдвэрлэл яваад үүнээс болоод энэ салбарын нийт үйлдвэрлэлд бас сөрөг нөлөө үзүүлээд байсан. Тийм учраас үүнийгээ та бүхэн онцгой анхаарал хандуулж холбогдох байгууллагуудтайгаа хамтарч, зээл олголтын ажлыг шуурхай зохион байгуулах ёстой. Зарим газрууд тодорхой санал тавьж байна. Сая Энхтүвшин гишүүн өвлийн хүлэмж, хүлэмжийн тухай. Тэгвэл бид хүлэмж рүү зориулаад 48 сарын хугацаатай, 6 хувийн хүүтэй 7 тэрбум төгрөгийн зээл гаргая гээд л ингээд л ярьж байна шүү дээ. Энэ хөрөнгийг говийн бүс рүү бас олгох, эрх юмнуудыг нь банкны системтэйгээ ярьж шийдэх хэрэгтэй. Тэгж байж энэ байгалийн энерги, тэр давуу нөөцийг ашиглаж, энэ газар тариалангийн салбарын зарим таримлуудын ургацын хэмжээг нэмэгдүүлэх бололцоо боломж чинь байгаа шүү гэдгийг би зориуд хэлмээр байна.

Жимсний аж ахуйнуудыг бас судалж, энэ харьцангуй давуу боломжтой, байгалийн өгөгдөлтэй бүс нутгууд руугаа чиглүүлэх асуудлыг бид анхаарах ёстой гэдгийг зориуд хэлмээр байна.

Дараагийн асуудал шатахууны асуудал байгаа. Үнэхээрийн байдал нөхцөл тийм амаргүй байгаа. Би Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдтай ярьсан. Хаврын тариалалт, урини

боловсруулалтад шаардлагатай шатахуун бэлэн үү гэсэн бэлэн гэнэ лээ. Гэхдээ бид нарын тооцож байгаагүй асуудлууд ороод ирэх вий. Тийм учраас энэ чинь жилийн дүнгээрээ 24 мянган тонн гэж явдаг урини, тариалалт хоёртоо бол би нэг 16 орчим мянган тонн шатахуун шаардлагатай болов уу гэж ингэж тооцож байгаа. Үүнийгээ өмнөх он жилүүдэд хамтран ажиллаж, нийлүүлж байсан шатахуун нийлүүлэгч нартайгаа гэрээ хэлцлээ эртхэн хийгээд хамтарч ажиллах бололцоо байгаа шүү. Зүгээр ер нь би бодоод байгаа юм. Засгийн газар Сангийн яам эд нартайгаа ярьж тэр өнөө технологийн нөөц, стратегийн нөөц бүрдүүлэх асуудал дээр тодорхой хөрөнгө тавьчхаад байгаа шүү дээ. Түүнийг энэ газар тариалангийн үйлдвэрлэлийг удирдах үйл ажиллагаанд бас тодорхой хэсгийг нь ашиглаж болмоор байгаа. Шатахууны нөөц энэ тэрээ бол тэр хөрөнгөөс тодорхой бүрдүүлээд тэртээ тэргүй л аж ахуйн нэгжүүдэд шатахуунаа нийлүүлээд намрынх нь ургац дээрээс ургацаа хураагаад, тэгээд нөөцлөх ёстой стратегийнхаа нөөц таваарын улаан буудайгаа нөөцөлчих бололцоо боломж бий. Би бол 25 он гэхэд бол Монгол Улс 100 мянган тонн таваарын улаан буудай буюу нөөцтэй, технологийн нөөц буюу нэг 18 орчим мянган тонн үрийн нөөцтэй болж чадна. Түүнийгээ сэлгэх, шинэчлэх, нөхөн бүрдүүлэх зарчмаар цаашид тасралтгүй явах бололцоо нь бүрдэнэ. Энэ нь манай газар тариалангийн үйлдвэрлэлд дан дамаа энэ үр тарианы үйлдвэрлэлд нэлээн том үр дүн авчирна л гэж л ингэж л харж л бодлогын баримт бичгүүдээ баталсан л гэж л ингэж л ойлгож байгаа шүү дээ.

Дээр нь бидэнд төмсний асуудал дээр бас энэ үр бүрдүүлэлтийн асуудал байгаад байх шиг байгаа юм. Хүнсний ногоон дээрээ байгаад байгаа. Энэ нь холбогдох та хэдийн энэ хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд хийгдэж байгаа ажлын хүрээнд байна.

Дээр нь өнөө хөрс хамгаалалт, талбайн хамгаалалтынхаа хүрээнд хашаажуулалтынхаа юмыг бас бид тодорхой авч хэрэгжүүлэх ёстой. Энэ нь эргээд энэ тариалсан талбайн хамгаалалт, ургацын хорогдол юмыг бууруулахад их том үүрэг гүйцэтгэдэг учраас үүнийгээ давхар анхаарч ажиллана шүү гэдгийг би зориуд хэлмээр байна.

Ингээд гишүүд санал хэлж дууслаа.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа.

18.28 цаг

Ингээд өнөөдрийн хуралдааныг хааж байна.

Өнөөдрийн хуралдаанд оролцсон Байнгын хорооныхоо гишүүд, ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ